



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Удирдах зөвлөлийн дарга, орлогч даргыг  
сонгох, томилох тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.5 36.7 дугаар заалтууд, БСШУС-ын Сайдын 2018 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн А/272 дугаар тушаал, ШУТИС-ийн дүрмийн 4.2, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 2.7, 2.8 дугаар заалтууд, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн хурлын тэмдэглэл, Удирдах зөвлөлийн гишүүдийн нээлттэй санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Үүсгэн байгуулагчийн санал болгосноор ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн даргаар Удирдах зөвлөлийн гишүүн, БСШУС-ын Сайдын зөвлөх Б.Ганбатыг сонгосугай.
2. Үүсгэн байгуулагчийн санал болгосноор ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн орлогч даргаар Удирдах зөвлөлийн гишүүн, БСШУСЯ-ны Дээд боловсролын бодлогын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Т.Амаржаргаланг сонгосугай.

ДАРГА



Б.ГАНБАТ



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

### Элсэлтийн хяналтын тоо батлах тухай

Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн 7.2 дахь хэсэг, Удирдах зөвлөлийн 2018 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуульд 2018-2019 оны хичээлийн жилд элсүүлэх бакалавр оюутны элсэлтийн хяналтын тоог хавсралтаар баталсугай.
2. Хяналтын тоонд багтаан, элсэлтийн үйл ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал /Б.Очирбат/-д даалгасугай.

ДАРГА



Б.ГАНБАТ



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

### Оюутны байрны төлбөр тогтоох тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.4 дугаар заалт, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.6 дугаар заалт, Удирдах зөвлөлийн 2018 оны 5-р сарын 25-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. ШУТИС-ийн 2018-2019 оны хичээлийн жилд мөрдөгдөх оюутны байрны төлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Оюутны байрны орчин, нөхцөлийг сайжруулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал Л.Баяр-Эрдэнэ, холбогдох бүрэлдэхүүн сургуулийн захирлуудад үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ГАНБАТ

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 05 дугаар сарын 25 -ны өдрийн 09 тоот тогтоолын хавсралт



ШУТИС-ийн 2017-2018 оны хичээлийн жилд мөрдөх оюутны байрны төлбөр

	сургууль	Өрөөний багтаамж, зориулалт	Сарын төлбөрийн хэмжээ (мян.төг)		
			Нэг оюутан	Нэг айл өрх /цахилгааны төлбөр орохгүй/	Оюутнаас авах барьцаа /жилд/
1	БУХС	2 хүний	55.0	170.0	30.0
		4 хүний	40.0	200.0	30.0
2	ДТС	4 хүний	40.0	-	30.0
3	МТС	4 хүний	40.0	200.0	30.0
4	МХТС	4 хүний	45.0	120.0	30.0
5	ҮТС	4 хүний	40.0	200.0	30.0
		1 хүний люкс	264.0		
		2 хүний люкс	234.0		
		2 хүний энгийн	216.0		